



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт барьж, ашиглалтад оруулсан өндөр төвөгшилтэй ангиллын 3000 м3 хүчин чадал бүхий аймгийн төвийн Цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний зориулалттай нийт 9,099,752,721.79 (есөн тэрбум ерэн есөн сая долоон зуун тавин хоёр мянга долоон зуун хорин нэгэн төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг Архангай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Х.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай аймагт бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгийн задаргаа, зориулалтыг харгалзан эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

13201039

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн
43... дугаар тогтоолын хавсралт



АРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Гүйцэтгэлийн дүн
1	Захиргаа, аж ахуйн барилга	734,028,892.91
2	Үйлдвэрийн барилга	1,424,523,645.28
3	Механик сараалжийн барилга	847,594,946.07
4	Биологи цэвэрлэгээний блок	2,078,428,633.73
5	Бохир усны насос станцын барилга	233,379,283.52
6	Дренажийн насос станцын барилга	233,464,019.49
7	Элс, лаг нүүрсний талбайн ажил	602,886,179.27
8	Зам талбай хашааны ажил	644,155,473.80
9	Харуулын байр	40,543,100.40
10	Шугам хоолойн ажил	242,434,311.11
11	Талбай доторх шугам /дулаан, цэвэр бохир ус/	57,636,728.48
12	Био-цөөрмийн ажил	392,399,695.80
13	Биологи цэвэрлэгээний блок самбар удирдлага	41,839,080.48
14	Гадна гэрэлтүүлгийн ажил	84,732,885.55
15	Гадна цахилгаан хангамж 10 кВ кабель шугам	151,507,867.34
16	0.4 кВ-ын кабель шугам /нам хүчдэл/	19,401,226.50
17	400 кВа дэд өртөө	79,457,842.41
18	Дэд өртөөний барилга	263,233,984.61
19	Өргөх насос станцын ажил	808,104,735.92
20	Үерийн далангийн ажил	120,000,189.13
Нийт дүн		9,099,752,721.79
		(есөн тэрбум ерэн есөн сая долоон зуун тавин хоёр мянга долоон зуун хорин нэгэн төгрөг далан есөн мөнгө)